



HAL
open science

. 1947

Raphael Blanchier

► **To cite this version:**

Raphael Blanchier. . 1947 . L'influence de G. Dolgorsüren sur l'évolution de la danse mongole, Conservatoire national de musique et danse de Mongolie, 2023. halshs-04557970

HAL Id: halshs-04557970

<https://shs.hal.science/halshs-04557970>

Submitted on 24 Apr 2024

HAL is a multi-disciplinary open access archive for the deposit and dissemination of scientific research documents, whether they are published or not. The documents may come from teaching and research institutions in France or abroad, or from public or private research centers.

L'archive ouverte pluridisciplinaire **HAL**, est destinée au dépôt et à la diffusion de documents scientifiques de niveau recherche, publiés ou non, émanant des établissements d'enseignement et de recherche français ou étrangers, des laboratoires publics ou privés.



Distributed under a Creative Commons Attribution - ShareAlike 4.0 International License

МУАЖ Г.Долгорсүрэн 1947 онд Прага хотод болсон Дэлхийн Залуучууд Оюутны анхдугаар фестивальд оролцсон тухай

Доктор Бланшиэ Рафаел, Монгол бүжиг судлаач, хүн судлаач, Франц Улсын Клермон Овэрнийн дэд професор, бүжиг судлалын ангийн эрхлэгч

МУАЖ Г.Долгорсүрэн багшдаа хүндэтгэл үзүүлж энэхүү бага хурал номд хувь нэмрээ оруулж байгаа нь миний хувьд нэр төрийн хэрэг юм.

Гарамын Долгорсүрэн гуай 1923 онд Төв аймгийн Лүн сумын нутагт төржээ. жолоочоор бэлтгэгдээд 1942 онд Уран сайхны сургуульд элсэн орж Улсын хөгжимт драмын театрт жүжигчнээр ажиллаж, 1944 онд уран сайхны сургуульд бүжгийн анги нэгдэхэд монгол улсын хамгийн анхны бүжгийн мэргэжилтэй жүжигчдийн нэг болжээ. Мөн манай багш нь бусад олон арвин амжилтын дунд 1967 оноос БНМАУ-ын томилолтоор уран сайхны сургуулийн (өнөөдрийн Монгол улсын Консерватори) монгол ардын бүжгийн систематикийн дасгал, хичээлийн үндсийг тавьж (Долгорсүрэн 1985), үүний мэргэжлийн сургалтын бүтэн хөтөлбөрийг байгуулаж болох алдартай хүн юм (Оюун Н. & Саранчимэг Ч. 2012). Г. Долгорсүрэн гуайн олон арвин үран бүтээл, нөлөө бүхий судлага, сургалтын номуудийн талаар та бүх сайн мэддэг болохоор энэ талд дэлгэрэнгүй танилцуулж өгөх хэрэг үгүй байгаа юм. Харин энэхүү илтгэлээр МУАЖ Г.Долгорсүрэн 1947 онд Прага хотод болсон Дэлхийн Залуучууд Оюутны анхдугаар фестивальд оролцсон тухай манай багшийн намтарт тийм ч сайн мэддэггүй зүйлд би анхаарлаа хандуулахыг хүсч байна.

Миний хувьд монгол бүжгийн тухай 2010 оноос сурах болон эрдэм шинжилгээний методологоор судлах эхлэж монгол ардын язгуур бий биелгээ, монгол ардын тайзны буюу мэргэжлийн бүжгийн хоёрын талаар, эдний түүх, үламжлал, утга агуулга, хөдлөгөний онцлог, өнө үеийн суран дамжих байдал, хандлага, гэх мэтийн талаар бүжиг урлаг болон нийгэм ухааны чиглэлээр судлаад 2018 онд Парисийн Сорбонь их сургууль дахь *École Pratique des Hautes Études* гэдэг Институтад докторын зэрэг хамгаалсан юм. Тухайн судлагаа хийхээр 2013 оноос хөгжим бүжгийн коллежийн маань бүжгийн ангийн багш нартай хамтран ажиллаж, Н. Оюун багшийн тусламжаар Г. Долгорсүрэн гуайтай уулзан ярилцах боломж олдсондоо би азтай байсан юм.

МУАЖ Г.Долгорсүрэнгийн намтарын олон амжилттай зүйлийн дунд түүний 1947 онд Прага хотод болсон Дэлхийн Залуучууд Оюутны анхдугаар фестивальд оролцсон нь

тийм ч сайн судлагаагүй зүйл ч гэсэн миний бодлоор монгол бүжгийн түүхийг сайн ойлгохын нь нэг чухал юм байна. Энэ үйл явдлийн тухай 1993 онд гарсан Долгорсүрэнгийн бичсэн ном *Ээрэнцэг. Бөмбөгөр ногооны бүжигчид*. Энэ номонд маий багш өөрийн намтар, залуу насныхаа тухай бичиж, хамтрасан жүжигчид, бүжигчид нөхдийг танилцуулж, 1930-1950 оны үе түүх, тухайн цагийн БНМАУ-ын соёл урлагийн хандлага, олон улсын бодлогын талаар маш баялаг, сониролтой мэдээлэл ба мэдрэмжий түүхийг нь өгч олгодог юмсан.



Дэлхийн Залуучууд Оюутны анхдугаар фестивалийн франц улсын зарлал

1947 оны Прага хотод БНМАУ-ын төлөөлөгчдийн тухай хэдэн бодит элементүүдийг сануулж эхэлцгээе.

Дэлхийн Залуучууд Оюутны анхдугаар фестиваль хэрхэн, ямах зорилготой гэхээр 1947 онд Дэлхийн Ардчилсан Залуучуудын Холбоо, Олон Улсын Оюутны Холбооны удирдлаган дор 1945 онд ЗХУ-ын санаачилгаар байгуулагдсан залуучуудын хоёр байгууллага нь дэлхий даяар коммунизмд ойр залуучуудын байгууллагуудыг нэгтгэх зорилгоор байгуулагдсан болжээ. Эрхэм зорилго нь: Дэлхийн 2-р дайны хүчирхийллийн дараа олон улсын залуучуудыг цуглуулж Дэлхийн улсуудын хооронд найрамдал, энх тайван тэмдэглэх гэсэн үг юм. Прага хотод фестивалыг зохион байгуулахаар сонгосон нь бас утга учиртай байсан гэхээр 1939 оны нацистуудын эсрэг үймээн самуун, түүний дараа гарсан цуст хэлмэгдүүлэлт, олноор цөллөг, ялангуяа Германы амбан захирагч "Прагын яргачин" гэдэг үүний дараа аймшигтай хочоор нэрлэсэн Рейнард Хейдрихийн амийг хөнөөсөн хэргийн хариуд хөрш Лидице, Леяки хотыг устгаж байсныг дурсах явдал

юм. Тийм болохоор Дэлхийн Залуучууд Оюутны анхдугаар фестиваль Прага хотод болох гэж шидэгдсэн юм.



Дэлхийн Залуучууд Оюутны анхдугаар фестивалд БНМАУ-ын төлөөлөгчид ©Чинбат Ч. & Оюунчимэг

Г. Гэр бүлийн архив

Энэхүү Наадам Дэлхийн 2-р дайны хоёрын хооронд хүчтэй харилцааны талаар Г.Долгорсүрэн дээр дурдсан номондоо сэтгэл хөдлөлөөр бичсэн байдаг юм. Мөн хамт аялсан алдарт бүжигчин Ж. Алимахүү Монголын газар нутагт шууд сүйрээгүй гал тэрэгээр аялахдаа дайны улмаас сүйрсэн улс орныхоо өөрийн нүдээ харж зовлон зүдгүүрийг гайхшруулсан гэж хүүхдүүдтэйгээ өөрийн сэтгэл хөдлөө хуваалж байсан гэж охин нь Г. Оюунчимэг надад хэлэв.

Энх тайвныг тэмдэглэх албан ёсны шалтгааны дагуу ЗХУ-ын зүгээс бүх холбоотон улсуудаа энэ мэт өргөн олон улсын цуглаануудад цуглуулж, олон улсын коммунизмын төлөөх намын үзэл суртал баримтлалыг хөгжүүлэх улс төрийн стратеги байсан. Монгол улс 1924 оноос Оросын хувьсгалын жишээг дагаж Бүгд Найрамдах Монгол Ард Улс болсон бөгөөд Прага хотод дахь фестивалд улсын төлөөлөгчдийг явуулахгүй байх боломжгүй байсан юм. БНМАУ-ын 36 төлөөлөгчид нь албан талдаа Монгол хувьсгалт Залуучуудын эвлэлийн төв хорооны эхлэгч, Наадмыг зохион байгуулагч Чехословак улс болон Монгол улсын хооронд байгуулсан дипломат төлөөлөгч, элчин яамны газар байгаагүйг нөхөхөөр Гадаад Харилцааны Яамны нэг ажилтан, Дотоод Хэргийн Яамны нэг ажилтан хүрэлцэн оролцож, Соёл урлагийн талдаа Төв театрын 21 ажилтан, түүний

дотор Төв театрын найруулагч, таван дуучин, найман бүжигчин, найман хөгжимчин, таван циркийн уран бүтээлч, нэмэх бусад нь хоёр бөхт хоёр мэргэн харваач, нэг зураач, нэг кино оператор оролцсон болжээ. Найман бүжигчдийн дотор нэг нь Долгорсүрэн гуай мөн. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд тухайн үеийн Монгол улсын соёл урлагийн олон төрөлийг (дуу, бүжиг, хөгжим, кино театр, уран зураг, цирк, уран нугаралт зэрэг) танилцуулан илэрхийлэх зорилготой бөгөөд Эрийн гурван наадамын жишээгээр Монголын уламжлалт спортыг харуулах байх болжээ. Үүнд уламжлалт бөх, сур харваа орсон бөгөөд хурдан морины уралдааныг л төлөөлөх боломжгүй байсан гэж Долгорсүрэн хэлэв (Долгорсүрэн 1993: 36-37). Уран сайхны болон улс төрийн энэхүү давхар төлөөлөл нь ийм төлөөлөгчдийн зорилгыг эмзэг болгож байна: уран бүтээлчид уран сайхны илэрхийлэлийн янз бүрийн арга хэлбэрээр үндэстнээ илэрхийлэхийн тулд байдаг бөгөөд тэдний янз бүрийн зэрэглэлийн албан тушаалтнуудын удирдлаган дор ажиллаж байгаа нь олон улсын тайцанд Монгол Улсад дипломат байр суурь эзлэхэд үйлчилдэг юм.

Мөн тухайн фестивалийн тайзны урлагийн хөтөлбөрийг үзэхэд монгол бүжгийн түүхийн талаар сонирхолтой зүйл харагдана. Концерт буюу Тоглолтын хөтөлбөрт монгол, казах үндэсний хэдэн дуу, гурван бүжиг (би илүү дэлгэрэнгүй эргэн ирэх болно), Нацагдоржийн зохиосон Учиртай гурван толгой дуурийн хэсэг, уран нугаралтын үзүүлбэр багтжээ.

Тухайн үед монгол бүжиг нь ЗХУ-аас ирсэн зөвлөн багш нарын удирдлаган дор тайзны буюу мэргэжлийн чиглэлээр хөжлөх эхлэсэн л байжээ. 1926 онд Бөмбөгөр ногоо гэдэг хүмүүсийн нэрлэсэн (1931 оноос Улсын төв театр болсон) Ардын цэнгэлдэх хүрээлэнгийн исэлдсэн зэсээр хийсэн бөмбөгөр хэлбэртэй, модерн тайзтай байшин байгуулагдсан бөгөөд 1943 он хүртэл монголд мэргэжлийн бүжигчин байхгүй байсан болохоор тухайн театрын хөтөлбөрт бүжиг орсон ч гэсэн жүжигчид л бүжиг бүжиглээд байсан юм.



Бөмбөгөр ногоо буюу Улсын төв театр, зураач О. Цэвэгжав, 1942 онд

‘Бүжгийн талаар гэвэл 1943 онд төв театрт бүжиг анги байгуулан Зөвлөлтөөс бүжгийн мэргэжилтан урьж ажиллуулсан нь театрын үзүүлбэрт бүжгийн бие даасан хөтөлбөр бэлтгэж үзэгч олондоо толилуулсан юм. Зөвлөлтийн мэргэжилтэн Нина Владимировна Кузнецова бидэнд багшилж байв. Тэрбээр анх удаа бүжгийн үдэшлэг хэмээх бие даасан хөтөлбөр бэлтгэж Монголын болон Орос, Украин, Молдов ардын бүжиг голлосон бүжгийн тоглолтын төв театрын тайзнаа тавьж үзэгчдийн таашаал хүлээсэн нь манай театрт мэргэжлийн бүжигчид бэлтгэх эхлэлтийг тавьсан юм.’

гэж Долгорсүрэн бичэв (1993 : 17-18).



Улсын урлагийн сургуульд Н. В. Кузнецова багшийн зааж өгсөн балетын курс, 1943 онд ©Чинбат Ч. & Оюунчимэг Г. Гэр бүлийн архив



1943 онд Н. В. Кузнецова багшийн дэглээсэн Цэцэгт вальс – Чайковскийн хөгжимт ©Чинбат Ч. & Оюунчимэг Г. Гэр бүлийн архив

Н. Кузнецова Монгол жүжигчдэд балетын техникийг, ялангуяа пуент гэдэг хөлийн өлмий дээр бүжиглэх нь, зааж өгөөд алдарт болсон Ц. Тоомой, Д. Нанжид, Ж. Алимахүү, Б. Жавзан, Г. Долгорсүрэн гэх мэтээ мэргэжлийн бүжиг сурах эхлэсэн байж 1945-1946 оноос ЗХУ-ын Я. В. Романовский урьж ажиллуулаад Улсын урлагийн сургуульд

бүжгийн анги нээгдээд анх дугаар ангийн бүжигчдийг элсрүүлсэн байжээ. Бүжгийн багш, балетмейстер Я. В. Романовский Монголын бүжигчдэд зөвхөн балетын дасгал биш, харин Монголтой холбоотой сэдэвтэй дэглэсэн бүжгүүдийг (жишээ нь Анчин ба зээр гэдэг драматик бүжиг) хийх зааж өгсөн бөгөөд (Нанжид 2009) түүний удирдлаган дор Прагын фестивалийн бүжгийн хөтөлбөрөө бэлдэх эхлэсэн болжээ. Үүнд: Ээрэнцэг, Аханбээ, Дүрбэт буюу Дөрвөд буюу аягатай биелгээ орсон юм.

Үүний дундуур Ээрэнцэг бол Долгорсүрэн гуайн сэтгэлээр л хамгийн чухал бүжиг мөн. Бөмбөгөх ногооны театрын бүх найман бүжигчин дөрөв эрэгтэй, дөрөв эмэгтэй оролцсон байжээ. Ээрэнцэг гэхээр монгол Юуан хаадны үеийн ноёд хатадын ордны ёс, ёслол, намбатай хөдөлгөөн үзүүлч илэрхийлэх гэсэн утгатай бүжиг мөн. Хөгжмийн зохиолч нь Б. Дамдинсүрэн, бүжиг дэглээч нь Я. В. Романовский, либрет нь Б. Ринчен. Ринчен гуай Юуан ший гэдэг Юуан үеийн түүх, хаан хатны ордны ёс, ёслол илэгхийлэх гар бичмэлийг судлаад ийм сэдэвтэй бүжгийн либрет зохиосон юм (Ринчен 1958).



Дэлхийн Залуучууд Оюутны анхдугаар фестивальд үзүүлсэн Ээрэнцэг бүжиг ©Монгол улсын архив

Нөгөө талдаа бүжигчин Ж. Алимахүү гоцлолт Дүрбэт буюу Дөрвөд биелгээ гэдэг нэрлэсэн аягатай бүжиг бүжиглэсэн юм. Энэ хоёр жишээгээр нь Монголын төлөөлөл сонгодог бүжгээр биш харин үндэсний монгол бүжиг, нэг талд түүхэн, ногоо талд орон

нутгийн язгуур уламжлалт бүжгээр харуулаж байсан нь тодорхой. Уг нь энэ хоёр бүжгийн төрлөөс үндэсний монгол ардын бүжиг үүсч баялаж дээшээ хөгжсөн юм.



Дэлхийн Залуучууд Оюутны анхдугаар фестивалд Ж. Алимаахүүгийн бүжиглэсэн Дүрбэт биелгээ

©Чинбат Ч. & Оюунчимэг Г. Гэр бүлийн архив

Долгорсүрэнгийн гэрчлэлийг уншихад баяр наадам нь эдгээр бүх үндэстний соёл хоорондын уулзалт гэж ойлгогдох нэмэлт хэмжигдэхүүнтэй харагдаж байна. Наадмын нээлт нь үндэстнүүдийн соёл, хэл шинжлэлийн олон янз байдал дахь эв найрамдлын шинж тэмдгийн дор явагддаг. Долгорсүрэнгийн хэлснээр 1945 онд Новиковын хөгжим, Лев Ошанины үгээр зохиосон Дэлхийн ардчилсан залуучуудын холбооны сүлд дууг бүх хэлээр нэгэн зэрэг цуурайтахад хүн бүрийн сэтгэл хөдөлдөг болжээ. Хувцасны үзэсгэлэн нь шууд мэдрэгдэхүйц байдлаар харуулсан соёлын олон янз байдлаар дамжуулан бүх үндэстний төлөөлөгчдийн сониуч байдлыг төрүүлдэг байж:

‘Энэ Их Наадмын хөтөлбөрт орсон үндэсний хувцасны маяг үзүүлэх үзлэг их сонин байлаа. Тив дэлхийн олон улс гүрний янз бүрийн үндэсний эрт, одоогийн хувцасны загварыгт Чекословак болон Европын бусад орноос ирсэн зочид төлөөлөгчид их сонирхсон юм. Түүнд манай төлөөлөгчид монгол туургатныхаа ястан үндэстний эрт, одоогийн хувцас, ялангуяа бүтэн ёс журмаар нь өмссөн ноёд хатагтай нарын намба ёслолын хувцсыг өмсөж үзүүлсэн юм.’

Гэж Долгорсүрэн бичив (1993 : 40)

Үнэн хэрэгтээ, ийм байдлаар нэгтгэсэн үндэстнүүдийн олон янз байдлыг сонирхох нь Наадмын үеэр өдөр бүр уулзаж, бие биенээ гайхшруулдаг байсныг ойлгох ёстой:

‘Тэдний олонхи нь манай орны тухай, ялангуяа Монголын залуучуудын талаар төдий л мэддэггүй байсныг хэлэх хэрэгтэй. Тийм учрааё биднийг тун их сонирхож, бид ч тэднээс дутахгүй хар, шар, цагаан арьстай тийм олон янзын үндэстнийг нэгэн доор тийм олноороо хуран цугларсныг үзээгүйг хэлэх үү өмссөн зүүсэн гоёсон гоодсон байдлыг нь сонирхон өөр хооронд нь жишин харьцуулж сонирхож л байж билээ.’

Гэж Долгорсүрэн бичив (1993 : 40).

Дараа дараагийн хоёр жил тутамд болдог Дэлхий Залуучууд Оюутны фестивалд зориулсан монгол баримтат кинонуудын монтаж, тайлбараас үзэхэд бие биенээ сонирхох, ялангуяа анх удаагаа илэрсэн энэ сэтгэл цаг хугацаа өнгөрөх тусам буурахгүй байгааг харуулж байна. Бусдын өнгө аясыг харуулсан энэхүү дэлхийн анхдугаар их наадам нь Монголын соёлын бэлгэдэл болсон, социалист үндэстнүүдийн олон улсын тайзанд оруулах давхар боломж гэж Монголын талаас харж байна. Бланшиё 2018.

Долгорсүрэнгийн Монголын төлөөлөгчдийн тухай мэдүүлэг нь Монголын соёл гэж юу байдгийг харуулах төдийгүй бусад соёл иргэншилтэй танилцах гэсэн хоёр бие биенээ нөхөж буйг харуулж байна.

Энэ нь антропологич Рой Вагнерийн үзэл санааг маш сайн харуулж байгаа бөгөөд түүний хэлснээр "соёл" нь ялгаатай тулгарах замаар бий болдог (Wagner REF).

Долгорсүрэнгийн гайхалтай амьдралын жишээгээр бид ерөнхийд нь монгол бүжгийг дипломат стратеги (Цэцэнцолмон 2012), 20-р зууны орчин үеийн монголын онцлог гэж ойлгож болно.

Монголын түүхэнд үл мэдэгдэх энэ чухал мөчийг хөндлөнгийн гадаад хүний үзэж байгаагаар Монголын анд нөхөд, багш нарыг минь цочирдуулахгүй гэж найдаж байна. Энэхүү илтгэлээрнээ Монголын бүжгийн урлагийн анхдагчдын нэг МУГЖ Бүжигчин, гайхамшигтай Долгорсүрэн багшдаа хүндэтгэл үзүүлээсэй гэж найдаж байна.

Бүжиг, соёл урлаг бол өнөөгийн Монголын бахархалтай, эрх чөлөөтэй хамгийн сайхан баялаг гэдэгт би итгэлтэй байна. Түүний бүжгийг дэлхий дахинд дахин үзүүлж, өөрийн дуртай энэ улс орон, соёл урлагийг өөрийнх шигээ үргэлжлүүлэн таниулахыг хүсч байна.

Ном зүй

Бланшиэ Р. 2018 *Les danses mongoles en héritage : performance et transmission du bii biêlgee et de la danse mongole scénique en Mongolie contemporaine*, Докторын диссертаци, ЭПХЭ эрдэм шижилгээний хүрээлэн, Парис.

Вагнер Р. 1975 *The Invention of Culture*, University of Chicago Press, Chicago.

Долгорсүрэн Г. 1985 *Монгол ардын бүжгийн дасгалууд*, Улсын Хэвлэлийн Газар, Улаанбаатар.

Долгорсүрэн Г. 1993 *Ээрэнцэг. Бөмбөгөр ногооны бүжигчид*, Улаанбаатар.

Нанжид Д. 2009 *Монголын бүжгийн түүхэн уламжлал, хөгжлийн шинэ хандлага*, Соёлын дээд сургууль хэвлэсэн нь, Улаанбаатар.

Оюун Н. & Саранчимэг Ч. (эмхэтгэсэн нь) 2012 *Сэтгэлийн өргөл*, Монгол бүжгийн урлагийн зөвлөл, Улаанбаатар.

Ринчен Б. 1958 'Монголчуудын бүжиг наадам', *Соёл* n° 2: 30-34.

Цэцэнцолмон Б. 2012 'Хуваалцах уу, үгүй юү: биет бус соёлын өвийн тухай Монголчуудын маргаан', *Монголын орон зай ба соёлын өв* олон улсын эрдэм шижилгээний бага хурал, Парис.